"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨҮГ

БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр:	**Төрөл бүрийн эрвээхэй хаалтууд /гар, хийн, цахилгаан удирдлагатай/**
Тендер шалгаруулалтын дугаар:	**ЭҮТӨҮГ/20250102248**

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.	**Тендерийн цар хүрээ**	1.1.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "**Хууль**" гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид "**бараа**" гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.
		1.2.	Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.
		1.3.	Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ.
		1.4.	Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана.
2.	**Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг**	2.1.	Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.
3.	**Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж**	3.1.	Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
4.	**Худалдан авах ажиллагааны цахим систем**	4.1.	Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид "цахим систем" гэх/-ээр зохион байгуулна.
5.	**Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх**	5.1.	Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.
		5.2.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20[1], 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй

байна.

6.	**Сонирхогч этгээд, оролцогч**	6.1. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.
		6.2. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
		6.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
		6.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна.
		6.5. ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
7.	**Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ**	7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
		7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
		7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
		7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.
		7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
		7.6. ТШЗ-ны 7.1-д заасан гэрээнд түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэх үүрэг (тоо хэмжээ гэх мэт)-ийг үнийн дүнгийн хамт тодорхойлж, тусгасан байна.
8.	**Нийлүүлэх барааны гарал үүсэл**	8.1. ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.

Б.АГУУЛГА

9.	**Тендер шалгаруулалтын баримт бичиг**	9.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ: I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа; II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт; III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага; IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт; V Бүлэг. Тендерийн жишиг маягт; VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

9.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

9.3. Худалдан авах барааны онцлогоос хамаарч гэрээний нөхцөлийг VI бүлэгт заасан гэрээний нөхцөлөөс өөрөөр тодорхойлох шаардлагатай бол үндэслэлийг дурдаж хуулийн 39.3-т заасанд нийцсэн худалдан авах гэрээний нөхцөлийг баримталж болно.

9.4. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

10. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

10.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.

10.2. ТШЗ 10.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.

10.3. Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.

11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

11.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах (эсхүл ажлын талбайтай танилцуулах) бол өгөгдлийн хүснэгтэд заана.

11.2. Уулзалтад ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

11.3. ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.

12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13. Тендерийн иж бүрдэл

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. өгөгдлийн хүснэгтэд зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;

13.2.7. оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;

13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.10. түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

14. Тендерийн жишиг маягтууд

14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.

15. Хувилбарт санал

15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.

16. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг

16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.

16.2. Хэрэв өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 7.1-д заасан ерөнхий шаардлагыг магадлахтай холбоотой баримт бичгийг ирүүлнэ.

16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох болон ТШЗ-ны 16.2-т заасанд холбогдох баримт бичиг.

16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий шаардлагыг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.2, 16.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн Маягт 2-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.

17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.

17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.

17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.

17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.

17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.

17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тоног төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн барааанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.

17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;

17.9. Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл;

17.10. Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.

17.11. ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангаагүй гэж үзнэ.

17.12. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

18. Чадавхын болон туршлагын шаардлага

18.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба

хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.

18.2. Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна.

18.3. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д зааснаар өгөгдлийн хүснэгтэд тусгасан бол түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

18.4. Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

18.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

18.6. Оролцогч, түүний түншлэлийн гишүүний хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээллийг тендерт ирүүлэхийг шаардах бол өгөгдлийн хүснэгтэд заана.

19. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт

19.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан болон хуулийн 16.5-д хамаарах баримт бичгийн хүрээнд өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.

19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

19.3. Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасан бол Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

20. Техникийн чадавх болон туршлагын

20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах

шаардлагыг хангах нотлох баримт

бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан болон хуулийн 17.4-т хамаарах баримт бичгийн хүрээнд өгөгдлийн хүснэгтэд заана.

21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт

21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.

21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.

21.4. ТШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.

21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.

21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад заасан үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.

21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, дагалдах үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

22. Тендерийн валют

22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

22.2. Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаар, эсхүл захиалагч Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1-д заасан

Монголбанкнаас олгосон зөвшөөрөлд үндэслэн ТШЗ-ны 22.1-д заасан тендерийн валютыг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

23. Тендер хүчинтэй байх хугацаа

23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.

23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

24. Тендерийн баталгаа

24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.

24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

25. Тендер баталгаажуулах, илгээх

25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан цахим системд ирүүлэх ба тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ-ны 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт

бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа, тендер нээх

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

27. Тендерийн талаар тодруулга авах

27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13 дугаар зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.

29. Тендерийг үнэлэх

29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.

29.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

30. Арифметик алдааг залруулах

30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

31. Давуу эрх олгох

31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.

31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.

31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.

32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт

32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.

33. Тендерийн харьцуулах үнийг

33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-

тодорхойлох		ыг баримтална.
	33.2.	ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.
	33.3.	ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
34. Тендерийг эрэмбэлэх	34.1.	Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.
35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах	35.1.	Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална.
	35.2.	ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дүгээр зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
	35.3.	ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

36. Шийдвэр хүргүүлэх	36.1.	Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
37. Гүйцэтгэлийн баталгаа	37.1.	Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
	37.2.	Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах	38.1.	Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
	38.2.	Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: **"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨҮГ** Тендер шалгаруулалтын нэр: **Төрөл бүрийн эрвээхэй хаалтууд /гар, хийн, цахилгаан удирдлагатай/** Тендер шалгаруулалтын дугаар: **ЭҮТӨҮГ/20250102248**
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь багцтай эсэх: **Багцгүй**
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалт нь дотоодын үйлдвэрээс худалдан авах бараатай эсэх: **Бараагүй**
ТШЗ 1.4	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: **Үгүй**
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр: **Өөрийн хөрөнгө** Нийт төсөвт өртөг: **4,698,986,609.20** төгрөг
Б. АГУУЛГА	
ТШЗ 10.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: www.tender.gov.mn төрийн худалдан авах ажиллагааны цахим систем. Хүлээн авагчийн нэр: “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ Утасны дугаар: 7577-3504 Хаяг: Монгол Улс, Орхон аймаг Баян-Өндөр сум, Найрамдал талбай ш/х: 61027 Цахим шуудангийн хаяг: investdepartment@erdenetmc.mn Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоног байна. Тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д нийтлэх бөгөөд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд тендерт оролцохыг сонирхогч этгээдүүд цахим систем дэх тендерийн урилгын тодруулга, мэдээллийг байнга шалгахыг зөвлөж байна.
ТШЗ 11.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: **Үгүй**
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.1	Тендер шалгаруулалтын хэл: **Монгол хэл** Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг,

	захидал, бусад баримт бичиг, оролцогчдын ирүүлэх тендер Монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг баталгаат орчуулгын хамт бэлтгэн ирүүлнэ. ***Тендерийн материалыг Монгол хэл дээр ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.***
ТШЗ 12.4	Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн баталгаат орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран орчуулга үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.
ТШЗ 14.1	1. Оролцогч нь III бүлгийн техникийн тодорхойлолт, бараа нийлүүлэлтийн хуваарийг бөглөж ирүүлэх 2. Оролцогч нь V бүлэгт заасан Маягт №2-н дагуу мэдээллийг бөглөж ирүүлэх 3. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх 1-6 дугаар маягтыг бөглөж ирүүлнэ.
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг зөвшөөрөх эсэх: **Зөвшөөрөхгүй**
ТШЗ 16.2	Ерөнхий шаардлагыг магадлахтай холбоотой хуулийн 15.2-т зааснаас бусад нотлох баримт шаардах эсэх: : **Тийм** 1. Улсын бүртгэлийн гэрчилгээ 2. Татварын тодорхойлолт 3. Нийгмийн даатгалын тодорхойлолт 4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт 5. Оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэр (PDF)-т шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод, гаргацтай байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно. Тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар Монгол Улсын хуулийн дагуу хугацаа хэтэрсэн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөргүй байх шаардлагатай. Улсын бүртгэлийн гэрчилгээ, татвар болон нийгмийн даатгалын тодорхойлолтыг тендерийн баримт бичигт хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” (www.tender.gov.mn)-ээр дамжуулан шалгана.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлэх бөгөөд тодорхойлолт авах зааварчилгаатай www.tender.gov.mn цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсээс танилцана уу.Хэрэв шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг нэмэлтээр ирүүлнэ. **Хэрэв дээрх тодорхойлолтыг цахим системээр ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.**

ТШЗ 16.3	Гадаадын этгээд оролцох эрхтэй эсэх: **Эрхтэй** Гадаадын этгээдэд тавигдах баримт бичиг: Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ: 1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг 2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол пасспорт, түүнийг орлох баримт бичиг 3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татвар, нийгмийн даатгалын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг. Тендерийн өгөгдлийн хүснэгтэд заасан бусад баримт бичиг болон маягт эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг баталгаат орчуулгын хамт ирүүлнэ.
ТШЗ 17.4	Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: **Үгүй**
ТШЗ 17.5	1. Оролцогч, түүний нийлүүлэх бараа нь захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолтод нийцэж буйг тендер шалгаруулалтын баримт бичгийн техникийн тодорхойлолтод заасан хүснэгтийн дагуу харьцуулж ирүүлнэ. 2. Хэрэв санал болгох бараа нь техникийн тодорхойлолтын аль нэг үзүүлэлтээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбарыг нотлох баримтын хамт ирүүлсэн байна. /Нотлох баримт нь үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас эсхүл албан бичиг эсхүл тодорхойлолт байж болно./ [ТБОНӨХБАҮХАТ хуулийн 12.5-д зааснаар "эсхүл түүнтэй дүйцэх" гэсэн тодотгол хэрэглэсэн техникийн тодорхойлолтод өөр бараа санал болгосон оролцогч техникийн тодорхойлолтод заасантай дүйцэх болохыг энэ хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан баримт бичгээр, эсхүл бусад хэлбэрээр нотолсон бол техникийн тодорхойлолтыг хангасан гэж үзнэ]
ТШЗ 17.6	Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: **Үгүй**
ТШЗ 18.1	18.1.1. Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага шаардах эсэх: **Шаардана** 18.1.1.1. Оролцогчийн 2022, 2023, 2024 оны борлуулалтын орлого аль нэг жилд тендерт оролцогчийн санал болгож байгаа үнийн дүнгийн 70 хувиас багагүй байна. 18.1.1.2. Тендерт оролцогч нь 2022, 2023, 2024 оны аль нэг 2 жилд ашигтай ажилласан байна.

	18.1.1.3. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн нь тендерт оролцогчийн санал болгож байгаа үнийн дүнгийн 100 хувиас багагүй байна. 18.1.1.4. Оролцогчийн 2022, 2023, 2024 он тус бүрийн санхүүгийн тайлан e-balance цахим бүртгэлд шивэгдэж, баталгаажсан байх шаардлагатай. Санхүүгийн тайлан цахим бүртгэлд шивэгдэж, баталгаажаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно. 18.1.1.5. Банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөргүй байна. 18.1.2. Оролцогчид тавигдах техникийн болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага шаардах эсэх: **Шаардана** 18.1.2.1 Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт шаардах эсэх: **Шаардахгүй** 18.1.2.2 Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага шаардах эсэх: **Шаардана** Ижил төстэй бараа нийлүүлж байсан туршлагыг дараах байдлаар нотолно. Үүнд: 18.1.2.2.1. 2022, 2023, 2024 оны аль нэг жилд ижил төстэй бараа нийлүүлсэн байна. 18.1.2.2.2. Нийлүүлсэн ижил төстэй барааны үнийн дүн нь тендерт оролцогчийн санал болгож байгаа үнийн дүнгийн 70 хувиас багагүй байна. 18.1.2.2.3. Ижил төстэй гэдэгт **Төрөл бүрийн хаалтууд /гар, хийн, цахилгаан удирдлагатай/** нийлүүлж байсныг ойлгоно. 18.1.2.3 Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага шаардах эсэх: **Шаардахгүй**
ТШЗ 18.2	Тусгай зөвшөөрөл шаардах эсэх: **Шаардахгүй**
ТШЗ 18.3	Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна. Түншлэлийн гишүүн тус бүр ерөнхий шаардлага хангасан байх бөгөөд холбогдох мэдэгдэл, баримт бичгийг энэ хуулийн 7.2, 7.3-т зааснаар ирүүлнэ.
ТШЗ 18.6	Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл шаардах эсэх: **Шаардана**

	Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: Оролцогч нь өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг V бүлгийн Маягт 4-ийн дагуу ирүүлнэ.

ТШЗ 19.1	Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: **Тийм**
	
	1. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийг аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно. Үүнд:
	  1. Байгууллагын харилцагч банкан дахь харилцах дансны үлдэгдлийн мэдэгдэл
	  2. Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт
	  3. Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд
	
	2. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгдөж дуусаагүй зээлийн мэдээлэл “Хэвийн” бус байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно. Оролцогч “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг www.sainscore.mn, www.burenscore.mn хаягаар хандан авна. Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалзан үзэхгүй. *Жич: 2022, 2023, 2024 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр дамжуулан тендерт оролцогчдын баталгаажсан санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.*
	3. Сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлан. Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн хувьд худалдан авах ажиллагааны цахим системээс харах тул хавсаргах шаардлагагүй
	4. Сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл. Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн хувьд худалдан авах ажиллагааны цахим системээс харах тул хавсаргах шаардлагагүй
	5. Гадаадын хуулийн этгээд бол санхүүгийн тайланд аудит хийлгэх үүрэгтэй оролцогчийн хувьд санхүүгийн тайланд хийсэн 2022, 2023, 2024 он тус бүр аудитын дүгнэлт ирүүлнэ

ТШЗ 20.1	Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: **Тийм**

Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт:

1. Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл:

    1.1. Оролцогч нь үйлдвэрлэгч бол нотлох баримтыг ирүүлнэ (нотлох баримт гэдэгт албан ёсны цахим хуудас, компанийн танилцуулга эсхүл тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон баримтыг ойлгоно).

    1.2. Оролцогч нь үйлдвэрлэгчээс зөвшөөрөл авсан бол үйлдвэрлэгчийн зөвшөөрлийн хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.

    Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл гэдэгт дараах баримтуудын аль нэг нь байж болно. Үүнд: албан бичиг, хамтын ажиллагааны гэрээ, бусад нотлох баримт,

    1.3. Оролцогч нь үйлдвэрлэгчийг төлөөлөх албан ёсны этгээд бол дараах нотлох баримтыг ирүүлнэ (нотлох баримт гэдэгт албан ёсны цахим хуудас, эсхүл тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон баримт (албан бичиг эсхүл гэрээ)-ыг ойлгоно).

    1.4. Оролцогч нь үйлдвэрлэгчийг төлөөлөх албан ёсны эрхтэй этгээдээс зөвшөөрөл авсан бол дараах нотлох баримтыг ирүүлнэ (Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл олгох албан ёсны эрхтэй болохыг нотлох Компанийн дүрэм эсхүл Улсын бүртгэлийн гэрчилгээ эсхүл албан бичгийг ойлгоно).

2. Борлуулагчийн зөвшөөрөл:Оролцогч нь албан ёсны гэрээт борлуулагчаас зөвшөөрөл авсан бол дараах нотлох баримт бичгийг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ. Үүнд:

    2. 1. Гэрээт борлуулагч нь үйлдвэрлэгчтэй байгуулсан хамтын ажиллагааны гэрээ эсхүл албан ёсны гэрээт борлуулагчийн гэрчилгээний хуулбар эсхүл албан бичиг,

    2. 2. Оролцогч нь албан ёсны гэрээт борлуулагчтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ эсхүл албан бичиг.

3. Оролцогч нь V бүлгийн Маягт 3 "Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл", Маягт 5 "Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл"-ийн дагуу мэдээллийг бэлтгэн ирүүлнэ.
4. Бараа нийлүүлсэн гэрээ ба гэрээ дүгнэсэн акт (протокол эсхүл дүгнэлт эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг)-ын хуулбарыг ирүүлнэ. (Хэрэв "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай байгуулсан гэрээ бол нотариатаар батлуулах шаардахгүй)

ТӨХ-д шаардсан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.

ТШЗ 21.5	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: **Тохируулахгүй тогтмол байна**
ТШЗ 21.6	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: **Тийм** Дотоодын оролцогч: **Incoterms 2020 DDP** Гадаадын оролцогч: Incoterms 2020 DAP, CIP (Энэхүү нийт болон багц тус бүрийн үнэд "Incoterms 2020" DDP- "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах нөхцөлөөр тооцож тээврийн зардал, НӨАТ, гаалийн татвар багтсан болно. Хэрэв гадаадын оролцогч Incoterms 2020 DAP, CIP нөхцөлөөр үнийн санал ирүүлсэн тохиолдолд Монгол Улсад төлөх НӨАТ, гаалийн татвар хураамж, Замын-Үүдээс Эрдэнэт хүртэлх тээврийн зардал зэрэгт санал болгож буй үнийн дүнгийн 16,5%-ийг санал болгосон үнэ дээр нэмэгдүүлж ижил нөхцөл буюу "Incoterms 2020" DDP- "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ- ын агуулах нөхцөлтэй адилтган үнийн харьцуулалтыг тооцож үзэхийг анхааруулъя.)
ТШЗ 22.2	Тендерийн валют: **Төгрөг (₮)**
ТШЗ 24.1	Тендерийн баталгаа шаардах эсэх: **Шаардана** Тендерийн баталгааны дүн: **23,494,933.05** төгрөг
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 25.5	Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: 1. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
ТШЗ 26.2	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна. Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: **Орхон аймаг, Баян-Өндөр сум**
Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ	
ТШЗ 29.2	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: **Үгүй**
ТШЗ 31.1	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: **Давуу эрх тооцоход шаардлагатай холбогдох мэдээлэл, нотлох баримтыг ирүүлнэ.**
ТШЗ 32.1	Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: **Ашиглахгүй**
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ 37.1	

	Гүйцэтгэлийн баталгаа: Гэрээ байгуулах эрх авсан оролцогч гэрээ батлагдахаас өмнө **140,969,598.28** төгрөг үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг ирүүлнэ.

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ,ТАВИГДАХ ШААРДЛАГА

“Техникийн тодорхойлолт” хэсэгт “Барааны техникийн тодорхойлолт”-ыг хавсаргана. Тухайлбал, нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Барааны нэр: "ТӨРӨЛ БҮРИЙН ЭРВЭЭХЭЙ ХААЛТУУД /ГАР, ХИЙН, ЦАХИЛГААН УДИРДЛАГАТАЙ/" /Эсхүл түүнтэй дүйцэх/

№	**Захиалагчийн техникийн тодорхойлолт** (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)	**Санал болгож буй техникийн тодорхойлолт** **(**захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.**)**	**Тайлбар** (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
…			

Бараа: Ган хаалт 31с942р Ду800 Ру10 /цахилгаан хөтлүүртэй/ (эсхүл түүнтэй дүйцэх)

Хэмжих нэгж: ширхэг

Техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нөхцөл
1	Диаметр	мм	800	
2	Ажлын биеийн даралт	атм	10	Багагүй
3	Зориулалт		Булинга дамжуулах	
4	Удирдлага		Цахилгаан хөтлүүртэй	
5	Их биеийн материал		сталь 20Л	
6	Шаантаг (клин) төрөл		Резиндсэн /Гуммированный клин/	
7	Шаантаг /клин/ материал		12Х18Н9ТЛ	
8	Холболтын төрөл		Фланец	
9	Битүүмжлэлийн ангилал		А ГОСТ 9544	
10	Өндөр	мм	3065	
11	Урт	мм	1000	
12	Ажлын биеийн температурын дээд утга	°С	+80	Багагүй
13	Орчны температурын дээд утга	°С	40	Багагүй
14	Орчны температурын доод утга	°С	-40	Ихгүй
15	Жин	кг	3180	Ихгүй
Нэмэлт шаардлага				
16	Хэрэв өөр улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг санал болгосон тохиолдолд, захиалагчийн техникийн үзүүлэлтүүдтэй нийцэж байгааг нотлох баримт бичгийг ирүүлнэ			
17	Цахилгаан хөтлүүрийн хамт ирүүлэх.			
18	Тохирлын гэрчилгээг тендерийн баримт бичигт ирүүлэх.			

Бараа: Бөмбөлгөн хаалт /хийн удирдлагатай/ Flowserve PNEUMATIC ACTUATED Durco-Plug-Valve-G4-1'' flowserve (эсхүл түүнтэй дүйцэх)

Хэмжих нэгж: ширхэг

Техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нөхцөл
1	Хаалтны төрөл		Durco G4	
2	Диаметр	инч	1	
3	Ажлын биеийн даралт	бар	16	
4	Холболтын төрөл		Фланец ANSI 150	
5	Урт (Face-to-Face, A)	инч	5	
6	Их биеийн материал		316 SS	
7	Битүүмжлэлийн материал		PTFE	
8	Ажлын биеийн температур /дээд/	°C	260	Багагүй
9	Ажлын биеийн температур /доод/	°C	-20	Ихгүй
10	Удирдлагын төрөл		Automax® PNEUMATIC	
11	Удирдлагын агаарын даралт		2.5bar~8bar	
12	Тохируулах хүрээ		90° /± 5°/	
13	Холболтын стандарт		IS05211	
Нэмэлт шаардлага				
14	Хэрэв техникийн үзүүлэлтэд зааснаас өөр загвар, стандартаар үйлдвэрлэгдсэн бараа, материал санал болгосон тохиолдолд захиалагчийн үзүүлэлтэд нийцэж байгааг нотлох техникийн үзүүлэлт болон хянан судлах үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудсыг ирүүлнэ. Хэрэв цахим хуудсан дахь мэдээлэл тендерт оролцогчийн мэдээлэлтэй зөрүүтэй бол цахим хуудсан дахь мэдээлэлийг баримтална.			
15	Тохирлын гэрчилгээг тендерийн баримт бичигт ирүүлэх.			

Бараа: Бөмбөлгөн хаалт /хийн удирдлагатай/ Flowserve PNEUMATIC ACTUATED Durco-Plug-Valve-G4-1-1/2'' flowserve (эсхүл түүнтэй дүйцэх)

Үйлдвэрлэгчийн код: Durco G4 1-1/2"(38.1mm)-G4-2-1-C-000-T-0-M-3-3-A

Хэмжих нэгж: ширхэг

Техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нөхцөл
1	Хаалтны төрөл		Durco G4	
2	Диаметр	инч	1.5	
3	Ажлын даралт	бар	16	
4	Урт (Face-to-Face, A)	инч	6.5	
5	Их биений материал		316 SS	
6	Бүтүүмжлэлийн материал		PTFE	
7	Холболтын төрөл		Фланец ANSI 150	
8	Ажлын биеийн дээд температур	°C	260	Багагүй
9	Ажлын биеийн доод температур	°C	-20	Ихгүй
10	Ажиллах зориулалт		Ус, уур, хий	
11	Тохируулах хүрээ		90° /±5°/	
12	Удирдлагын агаарын даралт		2.5bar~8bar	
13	Удирдлагын тоноглолын төрөл		Automax® PNEUMATIC	
14	Удирдлагын холболтын стандарт		IS0 5211	
Нэмэлт шаардлага				
15	Хэрэв техникийн үзүүлэлтэд зааснаас өөр загвар, стандартаар үйлдвэрлэгдсэн бараа, материал санал болгосон тохиолдолд захиалагчийн үзүүлэлтэд нийцэж байгааг нотлох техникийн үзүүлэлт болон хянан судлах үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудсыг ирүүлнэ. Хэрэв цахим хуудсан дахь мэдээлэл тендерт оролцогчийн мэдээлэлтэй зөрүүтэй бол цахим хуудсан дахь мэдээлэлийг баримтална.			
16	Тохирлын гэрчилгээг тендерийн баримт бичигт ирүүлэх.			

Бараа: Бөмбөлгөн хаалт /хийн удирдлагатай/ Flowserve PNEUMATIC ACTUATED Durco-Plug-Valve-G4-2'' flowserve (эсхүл түүнтэй дүйцэх)

Үйлдвэрлэгчийн код: Durco 2"-G4-2-1-000-T-0-M-33-A

Хэмжих нэгж: ширхэг

Техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нөхцөл
1	Хаалтны төрөл		Durco G4	
2	Диаметр	инч	2	
3	Ажлын биеийн даралт	бар	16	
4	Урт (Face-to-Face, A)	инч	7	
5	Их биеийн материал		316 SS	
6	Битүүмжлэлийн материал		PTFE/PTFE	
7	Холболтын төрөл		Фланец ANSI 150	
8	Ажлын биеийн температур /дээд/	°C	260	Багагүй
9	Ажлын биеийн температур /доод/	°C	-20	Ихгүй
10	Тохируулах хүрээ		90° /±5°/	
11	Удирдлагын агаарын даралт		2.5bar~8bar	
12	Удирдлагын төрөл		Automax® PNEUMATIC	
13	Удирдлага холбох стандарт		ISO 5211	
Нэмэлт шаардлага				
14	Хэрэв техникийн үзүүлэлтэд зааснаас өөр загвар, стандартаар үйлдвэрлэгдсэн бараа, материал санал болгосон тохиолдолд захиалагчийн үзүүлэлтэд нийцэж байгааг нотлох техникийн үзүүлэлт болон хянан судлах үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудсыг ирүүлнэ. Хэрэв цахим хуудсан дахь мэдээлэл тендерт оролцогчийн мэдээлэлтэй зөрүүтэй бол цахим хуудсан дахь мэдээлэлийг баримтална.			
15	Тохирлын гэрчилгээг тендерийн баримт бичигт ирүүлэх.			

Бараа: Бөмбөлгөн хаалт /хийн удирдлагатай/ Flowserve PNEUMATIC ACTUATED Durco-Plug-Valve-G4-4'' flowserve (эсхүл түүнтэй дүйцэх)

Хэмжих нэгж: ширхэг

Техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нөхцөл
1	Хаалтны төрөл		Durco G4	
2	Диаметр	инч	4	
3	Ажлын биеийн даралт	бар	16	
4	Урт (Face-to-Face, A)	инч	9	
5	Их биеийн материал		316 SS	
6	Битүүмжлэлийн материал		PTFE/PTFE	
7	Холболтын төрөл		Фланец ANSI 150	
8	Ажлын биеийн темпратур / дээд/	°C	260	Багагүй
9	Ажлын биеийн температур /доод/	°C	-20	Ихгүй
10	Фланецны боолтны нүхний тоо		8	
11	Тохируулах хүрээ		90° /±5°/	
12	Удирдлагын агаарын даралт		2.5bar~8bar	
13	Удирдлагын төрөл		Automax® PNEUMATIC	
14	Удирдлага холбох стандарт		ISO 5211	
Нэмэлт шаардлага				
15	Хэрэв техникийн үзүүлэлтэд зааснаас өөр загвар, стандартаар үйлдвэрлэгдсэн бараа, материал санал болгосон тохиолдолд захиалагчийн үзүүлэлтэд нийцэж байгааг нотлох техникийн үзүүлэлт болон хянан судлах үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудсыг ирүүлнэ. Хэрэв цахим хуудсан дахь мэдээлэл тендерт оролцогчийн мэдээлэлтэй зөрүүтэй бол цахим хуудсан дахь мэдээлэлийг баримтална.			
16	Тохирлын гэрчилгээг тендерийн баримт бичигт ирүүлэх.			

Бараа: Бөмбөлгөн хаалт /хийн удирдлагатай/ Flowserve PNEUMATIC ACTUATED Durco-Plug-Valve-G431-2'' ANSI300 flowserve (эсхүл түүнтэй дүйцэх)

Хэмжих нэгж: ширхэг

Техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нөхцөл
1	Диаметр	инч	2	
2	Ажлын биеийн даралт	бар	51	
3	Урт (Face-to-Face, A)	инч	8.5	
4	Их биений материал		316 SS	
5	Битүүмжлэлийн материал		PTFE	
6	Холболтын төрөл		Фланец ANSI 300	
7	Тохируулах хүрээ		90° /±5°/	
8	Ажлын биеийн температур /дээд/	°C	260	Багагүй
9	Ажлын биеийн температур /доод/	°C	-20	Ихгүй
10	Удирдлагын агаарын даралт		2.5bar~8bar	
11	Удирдлага		2 талын хийн автомат	
12	Удирдлагын төрөл		Automax® PNEUMATIC	
13	Удирдлага холбох стандарт		IS0 5211	
Нэмэлт шаардлага				
14	Хэрэв техникийн үзүүлэлтэд зааснаас өөр загвар, стандартаар үйлдвэрлэгдсэн бараа, материал санал болгосон тохиолдолд захиалагчийн үзүүлэлтэд нийцэж байгааг нотлох техникийн үзүүлэлт болон хянан судлах үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудсыг ирүүлнэ. Хэрэв цахим хуудсан дахь мэдээлэл тендерт оролцогчийн мэдээлэлтэй зөрүүтэй бол цахим хуудсан дахь мэдээлэлийг баримтална.			
15	Тохирлын гэрчилгээг тендерийн баримт бичигт ирүүлэх.			

Бараа: Бөмбөлгөн хаалт /хийн удирдлагатай/ Flowserve PNEUMATIC ACTUATED Plug valve 1 inch WCABR1050-01 flowserve flowserve pneumatic actuated Plug valve 1 inch WCABR1050-01 (эсхүл түүнтэй дүйцэх)

Үйлдвэрлэгчийн код: WCABR1050-01

Хэмжих нэгж: ширхэг

Техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нөхцөл
1	Диаметр	инч	1	
2	Ажлын даралт	бар	16	
3	Их биеийн материал		Forged Carbon Steel ASTM A105	
4	Бөмбөлөгний материал		Stainless steel 316	
5	Битүүмжлэх материал		Teflon (PTFE)	
6	Холболтын төрөл		NPS /эрээсэн/	
7	Ажлын биеийн дээд температур	°C	260	Багагүй
8	Ажлын биеийн доод температур	°C	-20	Ихгүй
9	Техникийн шиферлэлт		1"-E-59-E-4-6-P-T-T-SE	
10	Ажиллах нөхцөл		Хий	
Нэмэлт шаардлага				
11	Хэрэв техникийн үзүүлэлтэд зааснаас өөр загвар, стандартаар үйлдвэрлэгдсэн бараа, материал санал болгосон тохиолдолд захиалагчийн үзүүлэлтэд нийцэж байгааг нотлох техникийн үзүүлэлт болон хянан судлах үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудсыг ирүүлнэ. Хэрэв цахим хуудсан дахь мэдээлэл тендерт оролцогчийн мэдээлэлтэй зөрүүтэй бол цахим хуудсан дахь мэдээлэлийг баримтална.			
12	Тохирлын гэрчилгээг тендерийн баримт бичигт ирүүлэх.			

Бараа: Хаалт Orbinox EX-01-150-HW-E (эсхүл түүнтэй дүйцэх)

Хэмжих нэгж: ширхэг

Техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нөхцөл
1	Диаметр	мм	150	
2	Ажлын биеийн даралт	атм	10	Багагүй
3	Өргөн	мм	60	
4	Өндөр	мм	652	
5	Жин	кг	21	Ихгүй
6	Удирдлагын төрөл		Гар	
7	Их биеийн материал		CF8M	
8	Хаагдах тольны суултын төрөл		Метал-метал	
9	Хаалтны резин жийрэг		PTFE	
10	Голын материал:		Зэвэрдэггүй ган	
11	Хутганы материал		AISI 316 зэвэрдэггүй ган	
12	Холболтын төрөл		фланц EN 1092 PN10 and ASME B16.5 (class 150)	
13	Ажлын биеийн температурын дээд утга	°C	110	Багагүй
Нэмэлт шаардлага				
14	Хэрэв техникийн үзүүлэлтэд зааснаас өөр загвар, стандартаар үйлдвэрлэгдсэн бараа, материал санал болгосон тохиолдолд захиалагчийн үзүүлэлтэд нийцэж байгааг нотлох техникийн үзүүлэлт болон хянан судлах үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудсыг ирүүлнэ. Хэрэв цахим хуудсан дахь мэдээлэл тендерт оролцогчийн мэдээлэлтэй зөрүүтэй бол цахим хуудсан дахь мэдээлэлийг баримтална.			
15	Тохирлын гэрчилгээг тендерийн баримт бичигт ирүүлэх.			

Бараа: Хавчих хаалт /хийн удирдлагатай/ FLOWROX PINCH VALVE PVE 6 inch PVE4A150-603L-SBRT/PU Flowrox (эсхүл түүнтэй дүйцэх)

Үйлдвэрлэгчийн код: PVE4A150-603L-SBRT/PU

Хэмжих нэгж: ширхэг

Техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нөхцөл
1	Хаалтны төрөл		PINCH VALVE	
2	Диаметр	инч	6	
3	Ажлын биеийн даралт	бар	16	
4	Их биеийн материал		Cast Iron	
5	Урт (Face-to-Face, A)	инч	14.8	
6	Холболтын төрөл		Фланец ANSI150	
7	Ажлын биеийн температур /дээд/	°C	130	Багагүй
8	Ажлын биеийн температур /доод/	°C	-25	Ихгүй
9	Доторлогооны материал		SBRT	
10	Удирдлагын төрөл		PNEUMATIC ACTUATOR	
Нэмэлт шаардлага				
11	Хэрэв техникийн үзүүлэлтэд зааснаас өөр загвар, стандартаар үйлдвэрлэгдсэн бараа, материал санал болгосон тохиолдолд захиалагчийн үзүүлэлтэд нийцэж байгааг нотлох техникийн үзүүлэлт болон хянан судлах үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудсыг ирүүлнэ. Хэрэв цахим хуудсан дахь мэдээлэл тендерт оролцогчийн мэдээлэлтэй зөрүүтэй бол цахим хуудсан дахь мэдээлэлийг баримтална.			
12	Тохирлын гэрчилгээг тендерийн баримт бичигт ирүүлэх.			

Бараа: Хийн удирдлагатай хаалт Orbinox VG DN100 (эсхүл түүнтэй дүйцэх)
Хэмжих нэгж: ширхэг

Техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нөхцөл
1	Диаметр	мм	100	
2	Ажлын биеийн даралт	атм	10	Багагүй
3	Урт	мм	57	
4	Өндөр /H/	мм	668	
5	Жин	кг	19	Ихгүй
6	Удирдлагын төрөл		PNEUMATIC CYLINDER	
7	Их биеийн материал		CF8M	
8	Хаалтны резин жийрэг		PTFE	
9	Хутганы материал		AISI 304 / AISI 316	
10	Холболтын төрөл		EN-1092 PN10 ASME B16.5 (class 150)	
11	Ажлын биеийн температурын дээд утга	°C	80	Багагүй
12	Ажлын биеийн температурын доод утга	°C	-20	Ихгүй
13	Хэрэглээ		Булинга	
Нэмэлт шаардлага				
14	Хэрэв техникийн үзүүлэлтэд зааснаас өөр загвар, стандартаар үйлдвэрлэгдсэн бараа, материал санал болгосон тохиолдолд захиалагчийн үзүүлэлтэд нийцэж байгааг нотлох техникийн үзүүлэлт болон хянан судлах үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудсыг ирүүлнэ. Хэрэв цахим хуудсан дахь мэдээлэл тендерт оролцогчийн мэдээлэлтэй зөрүүтэй бол цахим хуудсан дахь мэдээлэлийг баримтална.			
15	Тохирлын гэрчилгээг тендерийн баримт бичигт ирүүлэх.			

Бараа: Хийн удирдлагатай хаалт Orbinox VG DN250 (эсхүл түүнтэй дүйцэх)
Хэмжих нэгж: ширхэг

Техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нөхцөл
1	Диаметр	мм	250	
2	Ажлын биеийн даралт	атм	10	
3	Урт	мм	76	
4	Өндөр /H/	мм	1220	
5	Жин	кг	89	Ихгүй
6	Удирдлагын төрөл		PNEUMATIC CYLINDER	
7	Их биеийн материал		CF8M	
8	Хаалтны резин жийрэг		PTFE	
9	Хутганы материал		AISI 304 / AISI 316	
10	Холболтын төрөл		фланц EN-1092 PN16 & 25 ASME B16.5 (class 150 & 300)	
11	Ажлын биеийн температурын доод утга	°C	-20	Ихгүй
12	Ажлын температур	°C	80	Багагүй
13	Хэрэглээ		Булинга	
Нэмэлт шаардлага				
14	Хэрэв техникийн үзүүлэлтэд зааснаас өөр загвар, стандартаар үйлдвэрлэгдсэн бараа, материал санал болгосон тохиолдолд захиалагчийн үзүүлэлтэд нийцэж байгааг нотлох техникийн үзүүлэлт болон хянан судлах үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудсыг ирүүлнэ. Хэрэв цахим хуудсан дахь мэдээлэл тендерт оролцогчийн мэдээлэлтэй зөрүүтэй бол цахим хуудсан дахь мэдээлэлийг баримтална.			
15	Тохирлын гэрчилгээг тендерийн баримт бичигт ирүүлэх.			

Бараа: Хийн удирдлагатай хаалт Orbinox VG DN350 (эсхүл түүнтэй дүйцэх)
Хэмжих нэгж: ширхэг

Техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нөхцөл
1	Диаметр	мм	350	
2	Ажлын биеийн даралт	атм	10	Багагүй
3	Урт	мм	82.5	
4	Өндөр /H/	мм	1687	
5	Жин	кг	183	Ихгүй
6	Удирдлагын төрөл		PNEUMATIC CYLINDER	
7	Их биеийн материал		CF8M	
8	Хаалтны резин жийрэг		PTFE	
9	Хутганы материал		AISI 304 / AISI 316	
10	Холболтын төрөл		EN-1092 PN10 ASME B16.5 (class 150)	
11	Ажлын биеийн температурын доод утга	°C	-20	Ихгүй
12	Ажлын биеийн температурын дээд утга	°C	80	Багагүй
13	Хэрэглээ		Булинга	
Нэмэлт шаардлага				
14	Хэрэв техникийн үзүүлэлтэд зааснаас өөр загвар, стандартаар үйлдвэрлэгдсэн бараа, материал санал болгосон тохиолдолд захиалагчийн үзүүлэлтэд нийцэж байгааг нотлох техникийн үзүүлэлт болон хянан судлах үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудсыг ирүүлнэ. Хэрэв цахим хуудсан дахь мэдээлэл тендерт оролцогчийн мэдээлэлтэй зөрүүтэй бол цахим хуудсан дахь мэдээлэлийг баримтална.			
15	Тохирлын гэрчилгээг тендерийн баримт бичигт ирүүлэх.			

Бараа: Хийн удирдлагатай хаалт Orbinox VG DN500 (эсхүл түүнтэй дүйцэх)
Хэмжих нэгж: ширхэг

Техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нөхцөл
1	Диаметр	мм	500	
2	Ажлын биеийн даралт	атм	10	Багагүй
3	Урт	мм	121	
4	Өндөр /H/	мм	2198	
5	Жин	кг	341	Ихгүй
6	Удирлагын төрөл		PNEUMATIC CYLINDER	
7	Их биеийн материал		CF8M	
8	Хаалтны резин жийрэг		PTFE	
9	Хутганы материал		AISI 304 / AISI 316	
10	Холболтын төрөл		EN-1092 PN10 ASME B16.5 (class 150)	
11	Ажлын биеийн температурын доод утга	°C	-20	Ихгүй
12	Ажлын биеийн температурын дээд утга	°C	80	Багагүй
13	Хэрэглээ		Булинга	
Нэмэлт шаардлага				
14	Хэрэв техникийн үзүүлэлтэд зааснаас өөр загвар, стандартаар үйлдвэрлэгдсэн бараа, материал санал болгосон тохиолдолд захиалагчийн үзүүлэлтэд нийцэж байгааг нотлох техникийн үзүүлэлт болон хянан судлах үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудсыг ирүүлнэ. Хэрэв цахим хуудсан дахь мэдээлэл тендерт оролцогчийн мэдээлэлтэй зөрүүтэй бол цахим хуудсан дахь мэдээлэлийг баримтална.			
15	Тохирлын гэрчилгээг тендерийн баримт бичигт ирүүлэх.			

Бараа: Хийн удирдлагатай хаалт Orbinox VG DN700 (эсхүл түүнтэй дүйцэх)
Хэмжих нэгж: ширхэг

Техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нөхцөл
1	Диаметр	мм	700	
2	Урт	мм	181	
3	Ажлын биеийн даралт	атм	10	Багагүй
4	Удирдлагын төрөл		PNEUMATIC CYLINDER	
5	Их биеийн материал		CF8M	
6	Хаалтны резин жийрэг		PTFE	
7	Хутганы материал		AISI 304 / AISI 316	
8	Холболтын төрөл		EN-1092 PN10 ASME B16.5 (class 150)	
9	Ажлын биеийн температурын доод утга	°C	-20	Ихгүй
10	Ажлын биеийн температурын дээд утга	°C	80	Багагүй
11	Хэрэглээ		Булинга	
Нэмэлт шаардлага				
12	Хэрэв техникийн үзүүлэлтэд зааснаас өөр загвар, стандартаар үйлдвэрлэгдсэн бараа, материал санал болгосон тохиолдолд захиалагчийн үзүүлэлтэд нийцэж байгааг нотлох техникийн үзүүлэлт болон хянан судлах үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудсыг ирүүлнэ. Хэрэв цахим хуудсан дахь мэдээлэл тендерт оролцогчийн мэдээлэлтэй зөрүүтэй бол цахим хуудсан дахь мэдээлэлийг баримтална.			
13	Тохирлын гэрчилгээг тендерийн баримт бичигт ирүүлэх.			

Бараа: Эрвээхэй хаалт /удирдлагагүй дан хаалт/ Bray BUTTERFLY VALVE 8 INCH Series 30 wafer (эсхүл түүнтэй дүйцэх)

Үйлдвэрлэгчийн код: 30W-B1D3S6SE-8

Хэмжих нэгж: ширхэг

Техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нөхцөл
1	Сериал дугаар		Series 30	
2	Төрөл		Эрвээхэй хавхлаг	
3	Диаметр	инч	8	
4	Ажлын даралт	бар	17.2	
5	Урт	инч	2.5	
6	Ажлын биеийн температур /дээд/	°C	121	Багагүй
7	Ажлын биеийн температур /доод/	°C	-29	Ихгүй
8	Фланец		ANSI 150	
9	Их биеийн материал		SS316 (AISI 316 зэвэрдэггүй ган)	
10	Дискний материал		SS316 (AISI 316 зэвэрдэггүй ган)	
11	Битүүмжлэл		EPDM PTFE NBR VITON	
12	Удирдлагын төрөл		PNEUMATIC /Хийн удирдлагатай /	
13	Ашиглалтын зориулалт		ус, хий, булинга	
Нэмэлт шаардлага				

14	Хэрэв техникийн үзүүлэлтэд зааснаас өөр загвар, стандартаар үйлдвэрлэгдсэн бараа, материал санал болгосон тохиолдолд захиалагчийн үзүүлэлтэд нийцэж байгааг нотлох техникийн үзүүлэлт болон хянан судлах үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудсыг ирүүлнэ. Хэрэв цахим хуудсан дахь мэдээлэл тендерт оролцогчийн мэдээлэлтэй зөрүүтэй бол цахим хуудсан дахь мэдээлэлийг баримтална.
15	Тохирлын гэрчилгээг тендерийн баримт бичигт ирүүлэх.

Бараа: Эрвээхэй хаалт C200 Series - Wafer Butterfly Valve LW DN100 Tameson C200 Series - Wafer Butterfly Valve DN100 (эсхүл түүнтэй дүйцэх)

Үйлдвэрлэгчийн код: BFLW-100-10-BBD

Хэмжих нэгж: ширхэг

Техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нөхцөл
1	Ашиглах зориулалт		Гидрийн шингэнийг хаах	
2	Диаметр	мм	100	
3	Ажлын биеийн даралт	бар	10	
4	Гадна материал		A351 CF8M	
5	Дотор матириал		Резин EPDM white	
6	Дискийн материал		Зэвэрдэггүй ган	
7	Ажлын биеийн темпратурын дээд утга	°C	80	Багагүй
8	Ажлын биеийн темпратурын доод утга	°C	-20	Ихгүй
9	Удирдлагын төрөл		Lever, Gear	

Бараа: Эрвээхэй хаалт /Зөөлөн суудалтай/ MAPAG PNEUMATIC BUTTERFLY VALVE 2BAR70EN 4 inch DN16 Mapag (эсхүл түүнтэй дүйцэх)

Үйлдвэрлэгчийн код: 4BC55R150

Хэмжих нэгж: ширхэг

Техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нөхцөл
1	Диаметр	инч	4	
2	Ажлын биеийн даралт	бар	16	Багагүй
3	Зориулалт		Азотын хий болон хүчилтөрөгч дамжуулах	
4	Технологийн шаарлага		Free of oil and grease /Хаалт тос тосолгооны материалаас бүрэн цэвэрлэгдсэн байх/	
5	Удирдлагын төрөл		Pneumatic Square	
6	Их биеийн материал		1.0566 carbon steel	
7	Хутганы материал		CF8M	
8	Хаалтны резин		FKM - Fluorocarbon Elastomer /Фторт нүүрсустөрөгчит резин/	
9	Даралтын ангилал		Class-150	
10	Холболтын төрөл		Lug type	
11	Хаалтны болтны нүх		ASME B16.5 Class 150, Ø22 mm	

12	Ажлын биеийн температур дээд утга	°C	180	Багагүй
13	Ажлын биеийн температур доод утга	°C	-10	Ихгүй
Нэмэлт шаардлага				
14	Хэрэв техникийн үзүүлэлтэд зааснаас өөр загвар, стандартаар үйлдвэрлэгдсэн бараа, материал санал болгосон тохиолдолд захиалагчийн үзүүлэлтэд нийцэж байгааг нотлох техникийн үзүүлэлт болон хянан судлах үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудсыг ирүүлнэ. Хэрэв цахим хуудсан дахь мэдээлэл тендерт оролцогчийн мэдээлэлтэй зөрүүтэй бол цахим хуудсан дахь мэдээлэлийг баримтална.			
15	Тохирлын гэрчилгээг тендерийн баримт бичигт ирүүлэх.			

Бараа: Эрвээхэй хаалт /Зөөлөн суудалтай/ MAPAG PNEUMATIC BUTTERFLY VALVE 2BAR70EN 8 inch DN16 Mapag (эсхүл түүнтэй дүйцэх)

Үйлдвэрлэгчийн код: BN6CRC08YN1C

Хэмжих нэгж: ширхэг

Техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нөхцөл
1	Диаметр	инч	8	
2	Ажлын биеийн даралт	бар	16	Багагүй
3	Зориулалт		Азотын хий болон хүчилтөрөгч дамжуулах	
4	Технологийн шаарлага		Free of oil and grease /Хаалт тос тосолгооны материалаас бүрэн цэвэрлэгдсэн байх/	
5	Удирдлагын төрөл		Pneumatic actuator	
6	Их биеийн материал		ASTM A516 Gr. 70 нүүрстөрөгчит ган	
7	Хутганы материал		CF8M	
8	Хаалтны резин		FKM - Fluorocarbon Elastomer /Фторт нүүрсустөрөгчит резин/	
9	Даралтын ангилал		Class-150	
10	Холболтын төрөл		Lug type	

11	Хаалтны болтны нүх		ASME B16.5 Class 150, Ø22 mm	
12	Ажлын биеийн температур дээд утга	°C	180	Багагүй
13	Ажлын биеийн температур доод утга	°C	-10	Ихгүй
Нэмэлт шаардлага				
14	Хэрэв техникийн үзүүлэлтэд зааснаас өөр загвар, стандартаар үйлдвэрлэгдсэн бараа, материал санал болгосон тохиолдолд захиалагчийн үзүүлэлтэд нийцэж байгааг нотлох техникийн үзүүлэлт болон хянан судлах үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудсыг ирүүлнэ. Хэрэв цахим хуудсан дахь мэдээлэл тендерт оролцогчийн мэдээлэлтэй зөрүүтэй бол цахим хуудсан дахь мэдээлэлийг баримтална.			
15	Тохирлын гэрчилгээг тендерийн баримт бичигт ирүүлэх.			

Бараа: Эрвээхэй хаалт /хийн удирдлагатай/ Tameson BFLW-80-BAA-PD-006 DN80/PN16 (эсхүл түүнтэй дүйцэх)

Хэмжих нэгж: ширхэг

Техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нөхцөл
1	Диаметр	мм	80	
2	Ажлын биеийн даралт	бар	16	
3	Материалл		Зэвэрдэггүй ган	
4	Ажлын биеийн дээд температур	°C	110	Багагүй
5	Ажлын биеийн доод температур	°C	-10	Ихгүй
6	Холболтын төрөл		DIN 2633, 2566 & 2642 /Фланец/	
7	Мушгих момент /хамгийн их/	нм	49.6	
8	Битүүмжлэх материал		EPDM PTFE NBR VITON	
9	Их биений материал		SS304/SS316	
10	Дискний материал		SS304/SS316	
11	Ашиглалтын зориулалт		ус, хий, булинга	
12	Удирдлагын төрөл		PNEUMATIC	
Нэмэлт шаардлага				
13	Хэрэв техникийн үзүүлэлтэд зааснаас өөр загвар, стандартаар үйлдвэрлэгдсэн бараа, материал санал болгосон тохиолдолд захиалагчийн үзүүлэлтэд нийцэж байгааг нотлох техникийн үзүүлэлт болон хянан судлах үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудсыг ирүүлнэ. Хэрэв цахим хуудсан дахь мэдээлэл тендерт оролцогчийн мэдээлэлтэй зөрүүтэй бол цахим хуудсан дахь мэдээлэлийг баримтална.			
14	Тохирлын гэрчилгээг тендерийн баримт бичигт ирүүлэх.			

Бараа: Эрвээхэй хаалт /хийн удирдлагатай/ Flowx DN50/PN10 PNEUMATIC BUTTERFLY VALVE FLOWX (эсхүл түүнтэй дүйцэх)

Үйлдвэрлэгчийн код: FLOWX-PWBV

Хэмжих нэгж: ширхэг

Техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нөхцөл
1	Диаметр	мм	50	
2	Ажлын биеийн даралт	бар	10	
3	Их биеийн материал		Ductile Iron SS304/SS316 WCB Aluminium Alloy 2205 2507 1.4529	
4	Дискний материал		SS304/SS316 Aluminum Bronze Nylon Ductile Lron 2205 2507 1.4529	
5	Битүүмжлэл		EPDM PTFE NBR VITON	
6	Холболтын төрөл		PN10/PN16 ANSI150 DIN16 JIS10K/16K	
7	Ашиглалтын зориулалт		ус, хий, булинга	
8	Ажлын дээд температур	°C	+85	Багагүй
9	Ажлын доод температур	°C	-15	Ихгүй
10	Хийцлэлийн төрөл		MASS-SP67	
11	Удирдлагын төрөл		Pneumatic Actuator	
12	Урт	мм	42.0	
13	Өндөр	мм	309.5	
14	Удирдлагын урт	мм	139.5	

15	Удирдлагын өргөн	мм	71.0	
16	Жин	кг	4	Ихгүй
17	Стандарт		API609	
Нэмэлт шаардлага				
18	Хэрэв техникийн үзүүлэлтэд зааснаас өөр загвар, стандартаар үйлдвэрлэгдсэн бараа, материал санал болгосон тохиолдолд захиалагчийн үзүүлэлтэд нийцэж байгааг нотлох техникийн үзүүлэлт болон хянан судлах үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудсыг ирүүлнэ. Хэрэв цахим хуудсан дахь мэдээлэл тендерт оролцогчийн мэдээлэлтэй зөрүүтэй бол цахим хуудсан дахь мэдээлэлийг баримтална.			
19	Тохирлын гэрчилгээг тендерийн баримт бичигт ирүүлэх.			

Бараа: Эрвээхэй хаалт /хийн удирдлагатай/ Flowx DN65/PN16 PNEUMATIC BUTTERFLY VALVE FLOWX (эсхүл түүнтэй дүйцэх)

Үйлдвэрлэгчийн код: FLOWX-PWBV

Хэмжих нэгж: ширхэг

Техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нөхцөл
1	Диаметр	мм	65	
2	Ажлын биеийн даралт	бар	16	
3	Их биеийн материал		Ductile Iron SS304/SS316 WCB Aluminium Alloy 2205 2507 1.4529	
4	Дискний материал		SS304/SS316 Aluminum Bronze Nylon Ductile Lron 2205 2507 1.4529	
5	Битүүмжлэл		EPDM PTFE NBR VITON	
6	Холболтын төрөл		PN10/PN16 ANSI150 DIN16 JIS10K/16K	
7	Ашиглалтын зориулалт		ус, хий, булинга	
8	Ажлын дээд температур	°C	+85	Багагүй
9	Ажлын доод температур	°C	-15	Ихгүй
10	Хийцлэлийн төрөл		MASS-SP67	
11	Удирдлагын төрөл		PNEUMATIC /Хийн удирдлагатай /	
12	Урт	мм	45	

13	Өндөр	мм	339.5	
14	Удирдлагын урт	мм	162	
15	Удирдлагын өргөн	мм	80.5	
16	Жин	кг	5	Ихгүй
17	Стандарт		API609	
Нэмэлт шаардлага				
18	Хэрэв техникийн үзүүлэлтэд зааснаас өөр загвар, стандартаар үйлдвэрлэгдсэн бараа, материал санал болгосон тохиолдолд захиалагчийн үзүүлэлтэд нийцэж байгааг нотлох техникийн үзүүлэлт болон хянан судлах үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудсыг ирүүлнэ. Хэрэв цахим хуудсан дахь мэдээлэл тендерт оролцогчийн мэдээлэлтэй зөрүүтэй бол цахим хуудсан дахь мэдээлэлийг баримтална.			
19	Тохирлын гэрчилгээг тендерийн баримт бичигт ирүүлэх.			

Бараа: Эрвээхэй хаалт Butterfly valve DN80 JIS 10K FT509119 HYUNDAI HD170 (эсхүл түүнтэй дүйцэх)

Үйлдвэрлэгчийн код: FT509119

Хэмжих нэгж: ширхэг

Техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Үзүүлэлт	Нөхцөл
1	Диаметр	мм	80	
2	Ажлын биеийн даралт	бар	10	
3	Удирдлагын төрөл		Hand lever /9 байрлалаар түгждэг/	
4	Холболтын төрөл		Фланц /дээрээ 2нүхтэй байн	
5	Холболтын фланцын стандарт		ISO 5211 – F07	
6	Ажлын биеийн температурын дээд утга	°C	120	Багагүй
7	Ажлын биеийн температурын доод утга	°C	-20	Ихгүй
8	Стандарт		EN558 Цуврал20	
9	Бүтээгдэхүүний бүлэг		701702	
10	Төгсгөлийн стандарт		JIS B2239	
11	Их биеийн материал		Хөнгөн цагаан, Ширэм GGG40	
12	Даралтын үнэлгээ		JIS 10K	

Бараа нийлүүлэлтийн хуваарь

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Бараг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа	
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)
1	*2*	*3*	*4*	*5*	*6*	*7*
1	Ган хаалт 31c942p Ду800 Ру10 /цахилгаан хөтлүүртэй/	2.00	ширхэг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногт	
2	Бөмбөлгөн хаалт /хийн удирдлагатай/ Flowserve PNEUMATIC ACTUATED Durco-Plug-Valve-G4-1"	2.00	ширхэг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногт	
3	Бөмбөлгөн хаалт /хийн удирдлагатай/ Flowserve PNEUMATIC ACTUATED Durco-Plug-Valve-G4-1-1/2"	3.00	ширхэг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногт	
4	Бөмбөлгөн хаалт /хийн удирдлагатай/ Flowserve PNEUMATIC ACTUATED Durco-Plug-Valve-G4-2"	3.00	ширхэг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногт	
5	Бөмбөлгөн хаалт /хийн удирдлагатай/ Flowserve PNEUMATIC ACTUATED Durco-Plug-Valve-G4-4"	3.00	ширхэг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногт	

6	Бөмбөлгөн хаалт /хийн удирдлагатай/ Flowserve PNEUMATIC ACTUATED Durco-Plug-Valve-G431-2" ANSI300	3.00	ширхэг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногт	
7	Бөмбөлгөн хаалт /хийн удирдлагатай/ Flowserve PNEUMATIC ACTUATED Plug valve 1 inch WCABR1050-01	3.00	ширхэг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногт	
8	Хаалт Orbinox EX-01-150-HW-E	4.00	ширхэг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногт	
9	Хавчих хаалт /хийн удирдлагатай/ FLOWROX PINCH VALVE PVE 6 inch PVE4A150-603L-SBRT/PU	7.00	ширхэг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногт	
10	Хийн удирдлагатай хаалт Orbinox VG DN100	22.00	ширхэг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногт	
11	Хийн удирдлагатай хаалт Orbinox VG DN250	40.00	ширхэг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногт	
12	Хийн удирдлагатай хаалт Orbinox VG DN350	30.00	ширхэг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногт	
13	Хийн удирдлагатай хаалт Orbinox VG DN500	4.00	ширхэг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногт	
14	Хийн удирдлагатай хаалт Orbinox VG DN700	2.00	ширхэг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногт	

15	Эрвээхэй хаалт /удирдлагагүй дан хаалт/ Bray BUTTERFLY VALVE 8 INCH Series 30 wafer	2.00	ширхэг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногт	
16	Эрвээхэй хаалт C200 Series - Wafer Butterfly Valve LW DN100	2.00	ширхэг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногт	
17	Эрвээхэй хаалт /Зөөлөн суудалтай/ MAPAG PNEUMATIC BUTTERFLY VALVE 2BAR70EN 4 inch DN16	1.00	ширхэг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногт	
18	Эрвээхэй хаалт /Зөөлөн суудалтай/ MAPAG PNEUMATIC BUTTERFLY VALVE 2BAR70EN 8 inch DN16	6.00	ширхэг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногт	
19	Эрвээхэй хаалт /хийн удирдлагатай/ Tameson BFLW-80-BAA -PD-006 DN80/PN16	3.00	ширхэг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногт	
20	Эрвээхэй хаалт /хийн удирдлагатай/ Flowx DN50/PN10 PNEUMATIC BUTTERFLY VALVE	4.00	ширхэг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногт	
21	Эрвээхэй хаалт /хийн удирдлагатай/ Flowx DN65/PN16 PNEUMATIC BUTTERFLY VALVE	4.00	ширхэг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногт	

22	Эрвээхэй хаалт Butterfly valve DN80 JIS 10K FT509119	2.00	ширхэг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах	Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногт	

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

V БҮЛЭГ.ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД

Маягт 1.Тендер илгээх маягт

Маягт 2.Барааны үнийн задаргаа

Маягт 3.Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Маягт 4.Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 5.Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 6.Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

Маягт 1 **Тендер илгээх маягт**

[огноо]

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай ***[оролцогчийн нэр]*** нь танай байгууллагаас зарласан ***[тендер шалгаруулалтын нэр, дугаар]*** тендер шалгаруулалтад ***[үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр]*** төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, доор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид "**тендер**" гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.

2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцохтой холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна. Үүнд:

   2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;

   2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;

   2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй;

   2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.

3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.

4. Тендерт үнийн хөнгөлөлт ***["санал болгоно" эсхүл "санал болгохгүй" гэж бичих]***. ***[Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих]***.

5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш ***[ажлын 30 ба түүнээс дээш өдрийн тоо бичих]*** өдрийн хугацаанд хүчинтэй байна.[4]

6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.

7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.

8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

---

[4] Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол "*5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.*" гэж сольж бичнэ үү.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,

эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,

албан тушаал, гарын үсэг,

байгууллагын тамга, тэмдэг]:

Хаяг:

Маягт 2 **Барааны үнийн задаргаа**

1	*2*	*3*	*4*	*5*	*6*	*7*	*8*	*9*	*10*	*11*
№	**Барааны нэр**	**Гарал үүслийн улс**	**Тоо хэмжээ**	**Хэмжих нэгж, тун**	**Нэгж үнэ**	**Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4х6)**	**Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ**	**Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж**	**Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9)**	**Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх[5]**
1										*Тийм/Үгүй*
2										
...										
	Тендерийн нийт үнэ									

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]:

[5] Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх гэдэгт “тийм” гэж бөглөсөн бол түүнийг нотлох баримт бичгийг хавсаргана.

Маягт 3 **Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дуусан/

Маягт 4 **Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 5 **Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл**

Оролцогчийн нэр: *[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].*

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) □Үндсэн нийлүүлэгч □Түншлэлийн гишүүн □Туслан гүйцэтгэгч

Маягт 6 **Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл, тайлбар
1.		
2.		
..		

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ.ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

1.1. Энэ гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл доор дурдсан утгыг агуулна:

1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;

1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;

1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;

1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;

1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно.

1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;

1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;

1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад барааанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;

1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;

1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;

1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;

1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал“ гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Гэрээний тайлбар

1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:

1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.

1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.

1.2.3. Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.

1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.

1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ

Бараа нийлүүлэх

2.1 Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.

2.2 Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.

2.3 ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.

2.4 Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.

Бараа нийлүүлэх газар	2.5	Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.
Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах	2.6	Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.
	2.7	Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно: 2.7.1 Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй; 2.7.2 Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.
	2.8	Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.
	2.9	ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.
Барааг хүлээлгэн өгөх	2.10	Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
	2.11	Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.
Барааны гарал үүслийн улс	2.12	Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна.
	2.13	Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.
Баглаа боодол	2.14	Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хангана.
	2.15	Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно.
	2.16	Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө.
Худалдааны нөхцөл	2.17	Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 21.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана.
	2.18	ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.

Гүйцэтгэлийн баталгаа

2.19 Хуулийн 42.1-д зааснаар Гүйцэтгэлийн баталгаа гаргах Нийлүүлэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Нийлүүлэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.

2.20 Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Нийлүүлэгчийн Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:

2.20.1 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;

2.20.2 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;

2.20.3 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.

2.21 Захиалагч гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Нийлүүлэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.

2.22 ГЕН-ийн 2.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Нийлүүлэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.

2.23 Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 4.11-д заасан Чанарын баталгаа гаргасан тохиолдолд Гүйцэтгэлийг баталгааг чөлөөлнө.

ГУРАВ. ЗАХИАЛАГЧ

Барааг хүлээн авах

3.1 Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.

Шалгалт, туршилт

3.2 Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

3.3 Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.

3.4 ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.

3.5 Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.

3.6 Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.

Гэрээний үнэ

3.7 Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.

3.8 Гэрээний үнэд хуулийн 40.1.2-т заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.

Төлбөр төлөх

3.9 Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.

3.10 Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.

3.11 Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.

3.12 Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.

3.13 ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.

3.14 Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

3.15 Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.

ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА

Захиалагчийн хүлээх эрсдэл

4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:

4.1.1. Бараг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;

4.1.2. Нийлүүлэгч Бараг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой барааанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.

Даатгал

4.2. Нийлүүлэгч нь бараг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.

Доголдлыг илрүүлэх, арилгах

4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.

4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.

4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа, эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.

4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.

4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.

4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.

4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.

Чанарын баталгаа

4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.

4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат, эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.

4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 42.5, 42.6-д заасны дагуу баталгаажуулж болно.

4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.

4.14. Баталгаат, эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.

4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.

4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.

Алданги

4.17. Нийлүүлэгч нь бараг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.

4.18. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.

Оюуны өмчийн эрх зөрчих

4.19. Бараг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.

Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал

4.20. Бараг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.

4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.

4.22. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.

4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.

Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа

4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.

4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд, эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.

ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл

5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй:

5.1.1. Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй, эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;

5.1.2. Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн зөвшөөрөл, гэрчилгээний хугацаа дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;

5.1.3. Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.

5.1.4. Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй;

5.1.5. Нийлүүлэгч тендерт оролцох, бараа нийлүүлэх явцад авлигын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон;

5.1.6. Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;

5.1.7. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн.

5.2. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.

5.3. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.

Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл

5.4. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг

дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.

ЗУРГАА. БУСАД НӨХЦӨЛ

Төлөөлөгч

6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.

6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.

6.3. Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.

6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

Туслан гүйцэтгэгч

6.5. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй. Тендерт санал болгосноор туслан гүйцэтгэгчийг оролцуулах ба өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авах бөгөөд өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3 дахь заалт хангагдсан байна.

6.6. Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын доголдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцна.

Нууцлал

6.7. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нуцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.

6.8. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нуцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.

Мэдэгдэл

6.9. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.

6.10. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9-д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.

6.11. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.

6.12. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:

6.12.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;

6.12.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.

6.13. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

6.14. ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.

Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

6.15. Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:

6.15.1. ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан;

6.15.2. үнийн тохируулга хийсэн.

6.16. Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

6.17. ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.

Маргаан шийдвэрлэх

6.18. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

6.19. Талууд зөвшилцөж шийдвэрлэж эс чадвал Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Бусад

6.20. Гэрээний хүчинтэй байх хугацаанд гүйцэтгэгчийн зөвшөөрөл, эсхүл гэрчилгээний хүчинтэй байх хугацаа дуусгавар болох нөхцөл бий болсон бол хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө энэ талаар Захиалагчид мэдэгдэж, гэрээний үүргийг зөвшөөрөл, гэрчилгээний хугацаа сунгасан шийдвэр гарах хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх шийдвэрийг Захиалагч гаргаж болно.

6.21. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэрээ байгуулах албан тушаалтан энэ хуульд зааснаар нийтийн албан тушаалтны ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарыг бөглөсөн байна.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ	
ГЕН 2.5.	Бараа нийлүүлэх газар: **"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах**
ГЕН 2.6.	Бараа нийлүүлэх хугацаа: **Гэрээ байгуулагдснаас хойш 60 хоногийн дотор**
ГЕН 2.10.	Бараа хүлээлгэн өгөх нөхцөл: БарааND холбогдох баримт бичиг: **Тохирлын гэрчилгээ** Угсралт, суурилуулах: **Шаардахгүй**
ГЕН 2.14.	Баглаа, боодол: Баглаа боодол: Тухайн барааны онцлогоос шалтгаалсан стандарт, сав баглаа боодолтой байх шаардлагатай. [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөл, шаардлагыг хангасан байна.] [Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг бичих] Баглаа, боодлын шаардлага: [Баглаа, боодлын шаардлагыг бичих]
ГЕН 2.17.	Олон улсын худалдааны нөхцөл хэрэглэх эсэх: **Тийм** Дотоодын оролцогч: **Incoterms 2020, DDP-"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах** Гадаадын оролцогч: Incoterms 2020 DAP, CIP (Энэхүү нийт болон багц тус бүрийн үнэд "Incoterms 2020" DDP- "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын агуулах нөхцөлөөр тооцож тээврийн зардал, НӨАТ, гаалийн татвар багтсан болно. Хэрэв гадаадын оролцогч Incoterms 2020 DAP, CIP нөхцөлөөр үнийн санал ирүүлсэн тохиолдолд Монгол Улсад төлөх НӨАТ, гаалийн татвар хураамж, Замын-Үүдээс Эрдэнэт хүртэлх тээврийн зардал зэрэгт санал болгож буй үнийн дүнгийн 16,5%-ийг санал болгосон үнэ дээр нэмэгдүүлж ижил нөхцөл буюу "Incoterms 2020" DDP- "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ- ын агуулах нөхцөлтэй адилтган үнийн харьцуулалтыг тооцож үзэхийг анхааруулъя.)
ГЕН 3.8.	Үнийн тохируулга: Үнийн тохируулга хийх аргачлал: **Үнэ тохируулахгүй тогтмол байна.**
ГЕН 3.9.	Төлбөр төлөх хугацаа: **Бараа нийлүүлж, гэрээ дүгнэсэн акт батлагдсанаас хойш 30 хоногт**
ГЕН 4.2.	Даатгал: **[Даатгалын нөхцөлийг тухайн бараа нийлүүлэлтийн онцлог болон худалдааны нөхцөлүүдийг харгалзан тодорхойлно. Даатгалын төрөл заах]**
ГЕН 4.10.	Баталгаат хугацаа: Чанарын баталгаат хугацаа: 12 сар
ГЕН 4.11.	Чанарын баталгаа шаардах эсэх: **Шаардахгүй**
	Нийлүүлэгчийн төлөх алданги тооцох эсэх: **Тийм**

ГЕН 4.17.	Нийлүүлэгчийн төлөх алданги: Алдангийн хувь: хоног тутамд 0.1 % ба алдангийн нийт дүн нийт гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10 % -аас хэтрэхгүй байна.
ГЕН 4.18.	Захиалагчийн төлөх алданги тооцох эсэх: **Тийм** Захиалагчийн төлөх алданги: Алдангийн хувь: хоног тутамд 0.1 % ба алдангийн нийт дүн нийт гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10 % -аас хэтрэхгүй байна.

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.
Дугаар № ***[Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]***

..... хот/аймаг

Нэг талаас ***[захиалагчийн нэрийг бичих]*** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэ гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь ***[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]*** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.

2. Гэрээний үнийг Нийлүүлэгч ***[Нийлүүлэгчийн нэрийг бичих]***-ийн харилцах ***[Банкны нэрийг бичих]*** банкны ***[дансны дугаар бичих]*** дугаар дансанд шилжүүлнэ.

3. Доор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
   3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
   3.2. Нийлүүлэгчийн тендер, холбогдох маягт;
   3.3. Гэрээний тусгай нөхцөл;
   3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
   3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
   3.6. Техникийн тодорхойлолт;
   3.7. Бараа нийлүүлэлтийн хуваарь.

4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:

4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл:

Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл:

Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2025-09-26**
Тендер шалгаруулалтын төрөл: **Бараа**
Тендер шалгаруулалтын нэр: **Төрөл бүрийн эрвээхэй хаалтууд /гар, хийн, цахилгаан удирдлагатай/**
Тендер шалгаруулалтын дугаар: **ЭҮТӨҮГ/20250102248**
Нийт төсөвт өртөг: **4,698,986,609.20 төгрөг**
Тендер шалгаруулалтын арга: Нээлттэй

1. **"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨҮГ** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.

2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: ***Багцгүй***

3. Тендерийг 2025 оны 10 дугаар сарын 31-ны өдөр 09:00 цаг, минутаас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг 2025 оны 10 дугаар сарын 31-ны өдөр 09:10 цаг, минутад нээнэ.

4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: ***"Зөвшөөрөхгүй"***

5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: ***"Эрхтэй"***

6. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.

7. Тендерийн баталгаа шаардах эсэх: ***"Шаардана"***

Тендерийн баталгаа шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичгийн заасан үнийн бүхий тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.

8. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: ***"Үгүй"***

9. Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: ***"Үгүй"***

10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

Монгол, Орхон, Баян-Өндөр сум , Найрамдал талбай, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захиргааны 2-р байр, утас 75773501, info@erdenetmc.mn